



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/299

Хэрлэн сум

Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн
салбарын сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 18 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг тооцох, байгалийн нөөцийн ашиглалтыг хүрээлэн буй орчин, биологийн олон янз байдалд сөрөг нөлөө багатайгаар төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянан батлах явцад оролцогч талууд болон аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад 4,788,000 (дөрвөн сая долоон зуун наян найман мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /₮/	Нийт үнэ /₮/
1	Цайны завсарлага	ш/өдөр	84*2 удаа*2 өдөр	5,000	1,680,000
2	Өдрийн хоол	ш/өдөр	84*2 өдөр	18,500	3,108,000
	Нийт			4,788,000	